

АЖ ТОРЕХ
УХААН

Г.Ловор

ЭВСЭГ ГЭР БҮЛ



I
ангийнханд
зориулав

**Г.Ловор
Эвсэг гэр бүл**

Бага сургуулийн 1-р ангиийн сурагчдад зориулав.

Зураач	Л.Зулбадрах
	Д.Сугархүү
Хянан тохиолдуулагч	О.Мөнхтуяа
Хянагч	Ж.Гэрэлмаа
Хэвлэлийн эх бэлтгэсэн	Н.Хөдөлмөр
	Д.Хишигдэлгэр



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

Эвсэг гэр бүл

(Сурагчийн зохион бичлэг)

Бид өглөө босоод тамирын дасгал хийдэг. Аав удирдаж, зэж дүү бид дагана. Биеийн чилээгээ ингэж гаргаад цайгаа уухаар ширээ тойрч суулаа. Ээжийн зүссэн талханд намайг тос түрхэхэд дүү бас элбэлцэв.



Аав хараад:

- Ямар ажилсаг хүүхдүүд вэ? Хэмээн үгээр урам өгч, дүүг өхөөрдене.

Аав ээжийнхээ дунд сууж цайлахад талх бүр ч амттай болох шиг санагдана.



Аав зэж хоёр ажилдаа
явангаа дүүг цэцэрлэгт, намайг
сургуульд хүргэж өгөв.




Хичээл тараад би л гэртээ түрүүлж ирдэг нь аз.
Аав ээжийгээ өдрийн завсарлагаар ирэхэд гэрээ
цэвэрлэж, цайгаа чанаж суух шиг сайхан үйл гэж хаа
байх вэ?

Ээж:

- Аав нь ирсэн үү? гэсээр ирнэ.

Ээж хэдий завандаа амжуулчхав гэмээр хоолны гурил элдчихээд, бас аавын цамцыг индүүдэж харагдав.



Аав ч төдөлгүй ирлээ.

Би ногоо арилгаж, аав мах хэрчиж ээжид тусалдаг.
Ингэж заншсан болохоор бид хэнээр ч шаардуулалгүй
дор дороо л шамдана.

Арга ч үгүй шүү дээ. Үдийн амралт ганцхан цаг. Бид цаг алдалгүй ажлаа хамтарч хийдэг болохоор тавтай хооллож амждаг юм.



Би аав ээж хоёрыгоо хайрлаж хүндэлдэг. Тэдний үгнээс гардаггүй. Орой ажил тарахаар дүүгээ цэцэрлэгээс авчрах нь миний бас нэг үүрэг.

Орой намайг дүүгээ хөтлеөд иртэл аав ээж хоёр дэлгүүрээс авсан юмсаа дамжилж ирэх нь таарав.

Орцны үүдэнд сууж байсан хөрш айлын эмээ биднийг харчхаад:

- Эднийх эвсэг сайхан айл шүү. Айл ийм л байх ёстой хэмээн хүмүүст ярих нь сонсогдож билээ.




Бага сургуулийн 1-р ангийнханд зориулав.



Гэр бүлийн өдөр тутмын амьдралд хүүхэд идэвхтэй оролцож эдийн засгийн “Цагаан толгой”-д суралцана.



Гэр бүлийн хамтын хөдөлмөр хүний цаашдын амьдралын чухал сургууль болдог.



Гэр бүлийн хүрээнд аав, ээжийн эрхэлдээг ажил хөдөлмөр хүүхдэд аж төрөхийн хичээл болдог.



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Хөдөвэгийн боловсролыг дэмжих (READ) төсөл”-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.